



БАТЛАВ:

ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГЫН УУРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.БАТ-ЭРДЭНЭ

2025 оны 01..сарын 22-ны өдөр

САЙНШАНД СУМЫН ХОТ ТОХИЖИЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗОРИУЛЖ  
АВТО ГРЕЙДР НИЙЛҮҮЛЭХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### 1. Ерөнхий үзүүлэлт ба тавигдах шаардлага

1.1	2024-2025 онд үйлдвэрлэгдсэн, техникийн бүрэн туршилтанд орсон шинэ байна.
1.2	SDLG G9220 загвартай дүйцэхүйц.
1.3	Бүх жин 20 тонн-с ихгүй.
1.4	Механик удирдлагын системээр тоноглогдсон байна.
1.5	Хусагч хутга, түрэгч хутга, газар хагалах хадуур /соёо/ тоноглогдсон байна.
1.6	Урд хэсэгт шороо түрэх нэмэлт / хутга / ажлын төхөөрөмжтэй байна.
1.7	Хусагч хутганы урт 4000 мм багагүй.
1.8	Хусагч хутга 360° шилжилт хийх боломжтой байна
1.9	Хусагч болон түрэгч хутга газарт 70мм багагүй хэмжээнд шигддэг байна
1.10	Нийт урт 9000 мм ихгүй
1.11	Нийт өргөн 3000 мм ихгүй
1.12	Нийт өндөр 3200 мм ихгүй
1.13	Түлшний савны багтаамж 200 л багагүй
1.14	Ажиллах орчины тэмператур -40°C-ээс +45°C байна.
1.15	Монгол орны цаг агаарын нөхцөлд тохируулан сайжруулалт хийсэн бол давуу талыг тусгаж өгөх.
1.16	Ажлын төхөөрөмжийг бусад тоноглолоор тоноглох, холбох хэрэгсэлтэй байх.
1.17	Сэлбэг материалын олдоц ихтэй.
1.18	Түлш зарцуулалт мот/цагт 20-30 л ихгүй байх.
1.19	Буурашгүй сэлбэг материалын нөөцөнд: 6 ширхэг дугуй, тухайн техникт тохирсон аккумулятор 2 ширхэг, хусагч хутганы ир 1 ширхэг, түрэгч хутганы ир 1 ширхэг, анжисны шүд 3 ширхэг, кабин халаагч 1 ширхэг, хөдөлгүүр халаагч халуун тогоо 1 ширхэг байна.

### 2. Хөдөлгүүр

2.1	Турбо компрессор бүхий усан хөргөлтийн системтэй Евро2, WEICHAI, DACHAI болон түүнтэй дүйцэхүйц дизель хөдөлгүүртэй байх.
2.2	Хөдөлгүүрийн түлшний өндөр даралтын насос энгийн байх.
2.3	Хөдөлгүүрийн генератор, стартер болон бусад хөдөлгүүрийн мэдрэгчүүд 24V ажилладаг.
2.4	Түлшний систем нь бохирдлоос сэргийлэх системтэй байх.
2.5	Хөдөлгүүрийг хэт ачаалал авахаас хамгаалах системтэй байна.
2.6	Хөдөлгүүр тосолгоо багассан үед хөдөлгүүр цохигоос хамгаалсан цахилгаан винтелээр тоноглосон байна.
2.7	Хөдөлгүүрийн хүчин чадал 160 KW багагүй байх.

### **3. Хянах хэмжих хэрэгслүүд**

3.1	Авто ачигчийн ажиллагааг хянах удирдлагын компьютерээр тоноглогдсон байх.
3.2	Тосолгооны түвшин заагчтай байна.
3.3	Тулшний түвшин заагчтай байна.
3.4	Хөдөлгүүр ажилласан мот/цаг заагчтай байна.
3.5	Хөдөлгүүрийн тахир голын эргэлт тоологчтой байна.
3.6	Хөдөлгүүрийн хөргөх шингэний температур заагчтай байна.
3.7	Хурдны горим заагчтай байна.
3.8	Хурдны хайрцагны ажлын шингэний даралт хэмжигч заагчтай байх.
3.9	Гидро системийн шингэний температур заагчтай байна.
3.10	Хусагч хутганы хазайлтын хэмжих заагчтай байна.

### **4. Явах анги**

4.1	26.5-25R дугуйтай 4*4,6*6 хөтлөгчтэй байна.
4.2	Редуктор хий эргэлтээс хамгаалсан дифференциаль цоожлогчтой байна.
4.3	Хойд тэнхлэг хоорондын зайд 1000 мм багагүй.
4.4	Хурдны хайрцаг автомат ажиллагаатай, механик удирдлагатай байна.

### **5. Хурдны хайрцаг**

5.1	ZF төрлийн механик хурдны хайрцаг.
5.2	Явах хурд 40 км/ц багагүй.

### **6. Кабин-бүхээг**

6.1	Дуу чимээ, шороо тоосноос хамгаалсан битүү загвартай байна.
6.2	Суудал нь операторын биеийн жин, өндөрт тохируулах боломжтой, чичиргээ доргио шингээгчтэй байна.
6.3	Халуун ажиллах үед сэргүүцүүлэгчтэй, хүйтэнд ажиллах үед халаагчтай байна.
6.4	Хянах самбар нь хүний биед сөрөг нөлөө үзүүлэхгүй биед ядаргаа өгөхгүй техникийн бүрэн мэдээлэл болон анхааруулгыг өгдөг байх. Хянах хэмжих хэрэгслүүд нь стандарт тэмдэг, гэрлээр мэдээлэлдэг байх.
6.5	Салхины шил нарны туяа бууруулагчтай, хажуугийн цонх хажуу тийш шилжиж нээгддэг байх.
6.6	Операторыг буух, суухад зориулсан шат, бариулаар тоноглогдсон байх.

### **7. Гидро систем**

7.1	Гидро систем нь бохирдоос хамгаалсан системээр тоноглогдсон байх.
7.2	Систем нь хамгаалах хавхлагаар тоноглогдсон байх.
7.3	Үндсэн болон бусад гидро насоснууд давхар ажиллагаатай байх.
7.4	Ажлын шингэний төрөл марк нь нийтлэг ашиглагддаг шингэн байх.
7.5	Ажлын шингэний бак шингэний түвшинг хянах цонхтой байх.

### **8. Цахилгаан тоноглол**

8.1	24в тогтмол гүйдлийн цахилгаан хэлхээтэй байна.
8.2	12в 200 А/Ц ба түүнээс дээш багтаамжтай асаалтын системийн 2 ширхэг аккумулятортой байна.
8.3	Шаардлагатай үед цахилгааны тэжээлийг салгах ерөнхий салгагчтай байна.
8.4	Кабин болон ажлын төхөөрөмж, ар тал дээр гэрэлтүүлэгчтэй байна.
8.5	Цахилгаан хэлхээ тус бүр гал хамгаалагчаар тоноглосон байна.
8.6	24в-12в буураалах бууруулагчтай, хэрэглээний 12в-24в тэжээлийн залгууртай байна.

### **9. Аюулгүй ажиллагааны систем**

9.1	Цахилгаан дуут дохиогоор тоноглогдсон, ажлын үед анхааруулах тусгай шар дохиогоор тоноглосон байна.
-----	---

9.2	Хажуу болон ар талыг харах тольтой ажлын үед ухрах үйлдэл хийхэд анхааруулах дуут дохиотой, ухрах камертай болон 360° камертай бол давуу талтай.
9.3	Эд анги, агрегатын хэвийн ажиллагаа алдагдах үед анхааруулах гэрлэн ба дуут дохиотой байна.
9.4	Алсаас хянах Hi mate системээр тоноглогдсон байвал давуу тал болно.
9.5	Операторыг хамгаалах аюулгүйн дэр, суудлын бүстэй байна.
9.6	Ажлын болон хэвийн горимд шилжүүлэх түгжээтэй байна.
<b>10. Бусад</b>	
10.1	Нийлүүлэгч нь авто грейдерын бүтэц зохион байгуулалт, ашиглалт, аюулгүй ажиллагаа ба техник үйлчилгээний талаар механик, жолооч нарт 40 цагаас багагүй онол ба дадлагын сургалт зохион байгуулна.
10.2	Хуурай нутаг бүхий гал унтраагуур 2 ширхэг, засвар үйлчилгээнд шаардлагатай багаж, товуд насос, тосны шүүр тайллагч зэргийг дагалдуулж өгнө.
10.3	Баталгаат хугацаа 1 жил буюу 2000 мот/цаг байх ба баталгаат хугацаан дахь техник үйлчилгээ болон шаардлагатай сэлбэг, тосолгооны материалыг нийлүүлэгч тал хариуцана.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ ХЯНАСАН:  
ХБТХОХ-ИЙН ДАРГА

Ц.МӨНХ-ЭРДЭНЭ

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН:  
САЙНШАНД ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ГАЗРЫН ДАРГА

Ч.ЭНХБААТАР